# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 06 дугаар сарын 24
№ 24 (1222)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 451. | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1726 |


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 452. | Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай | Дугаар 23 | 1728 |
| 453. | Хянан шалгах түр хороо байгуулах тухай | Дугаар 31 | 1764 |


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 454. | Журам шинэчлэн батлах тухай | Дугаар 1 | 1768 |


## ᠭᠠᠷᠴᠠᠭ

### ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ


᠔᠕᠑ ᠂ ᠡᠷᠦᠭᠦ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭ ᠬᠢᠨᠠᠨ ᠰᠢᠶᠳᠪᠦᠷᠢᠯᠡᠬᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ᠂ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠑᠗᠒᠖


### ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ


᠔᠕᠒ ᠂ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠥᠭᠵᠢᠯ ᠦᠨ ᠒᠐᠒᠓ ᠣᠨ ᠤ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠭᠡ ᠶᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠒᠓ ᠑᠗᠒᠘

᠔᠕᠓ ᠂ ᠬᠢᠨᠠᠨ ᠰᠢᠯᠭᠠᠬᠤ ᠲᠦᠷ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠓᠑ ᠑᠗᠖᠔


### ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ


᠔᠕᠔ ᠂ ᠳᠦᠷᠢᠮ ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠑ ᠑᠗᠖᠘

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр — Улаанбаатар хот

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5, 6, 7 дахь хэсэг нэмсүгэй:

“5.Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна.

6.Шүүх энэ зүйлийн 5-д заасан үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах бол энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдолд тусгасан асуудлыг шийдвэрлэх, шүүгдэгчид зүйлчлэлийг өөрчлөн сонсгох, мэдүүлэг өгөх эрхийг хангах, яллах дүгнэлтийг гаргуулах ажиллагаа явуулахыг прокурорт даалгах ба прокурор шүүхээс тогтоосон хугацаанд эдгээр ажиллагааг явуулж, шүүх хуралдаанаар хэлэлцүүлнэ.

7.Энэ зүйлд заасан үндэслэлээр шүүх хуралдаан хойшлогдсон тохиолдолд шүүх хуралдааныг энэ хуульд заасан журмаар эхнээс нь явуулна. Энэ зүйлд заасны дагуу шүүх хуралдааныг хойшлуулсан шийдвэрт гомдол гаргахгүй.”

**2 дугаар зүйл.**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

“3.Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцаана.”

**3 дугаар зүйл.**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12.Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй.”

**4 дүгээр зүйл.**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг, 39.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг, 40.8 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Г.ЗАНДАНШАТАР**

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 23 | Улаанбаатар хот

**Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан тус төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, цаашид улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгасан улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;

2/Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл хангаж ажиллах;

3/улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар, чиглэлийг тодорхойлж, хөгжлийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн тусгах, түүнчлэн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт бүрийн хэрэгжилтийг үнэлэх боломжтойгоор төлөвлөгөөний төслийг боловсруулах;

4/хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулах, түүнд санал ирүүлэх, хэрэгжилтийг үнэлэх талаар салбар, орон нутгийн хэмжээнд холбогдох байгууллага, албан тушаалтныг нэгдсэн арга зүй, удирдамжаар хангаж ажиллах.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

2022 ᠣᠨ ᠤ 6 ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 10 - ᠤ ᠡᠳᠦᠷ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ 58 ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible]

[illegible]

[illegible]

᠓ · ᠡᠨᠡ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠪᠢᠬᠤ ᠶᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠡᠳ᠋ ᠦᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠩᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠶ᠎ᠠ /ᠵ · ᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ/ - ᠳᠤ ᠳᠠᠯᠠᠯᠭᠠᠬᠤ ᠪᠠᠶᠢᠯᠭᠠᠭᠰᠠᠭᠠᠢ ᠄

᠔ · ᠡᠨᠡ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠢ ᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠑᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠒᠖- ᠤ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠮᠦᠷᠳᠡᠬᠦ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠭᠰᠤᠭᠠᠢ ᠄

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ · ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

Монгол Улсын Их Хурлын 2022 оны
23 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Бодлогын үндэслэл | Төсөл, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж | Үр дүнгийн үзүүлэлт | | 2023 онд шаардлагатай хөрөнгө | | Үндсэн хариуцагч | Хамтран хариуцагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суурь түвшин /2021 он/ | Зорилтот түвшин /2023 он/ | Санхүүжилтийн хэмжээ /сая.төг/ | Санхүүжилтийн эх үүсвэр | | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Бүлэг 1.Хүний хөгжлийн бодлого** | | | | | | | | | |
| **Зорилго 1.1.Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.** | | | | | | | | | |
| 1.1.1 | МУХТЖҮЧ-2.1.7, ЗГҮАХ-2.3.8 | Багшийн ур чадварыг сайжруулж, үнэлэмжийг дээшлүүлэх “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| 1.1.2 | МУХТЖҮЧ-2.1.2, ЗГҮАХ-2.3.3 | Суралцагчийн сургалтын ахиц дэвшлийн үнэлгээг хийж, ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулах | Бага, дунд боловсролын чанарын дундаж үнэлгээ, хувиар | 41 | 55 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| | | | Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын үнэлгээ /PISA/-нд тулгуурлан зөвлөмж боловсруулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3 | МУХТЖҮЧ-2.1.3, ЗГҮАХ-2.3.4 | Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, монгол хүний хандлага, хүмүүжил, төлөвшилд нийцсэн түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны агуулгаар баяжуулсан сургалтын хөтөлбөр боловсруулах | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | Соёлын яам |
| 1.1.4 | МУХТЖҮЧ-2.1.1, ЗГҮАХ-2.3.2 | Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх | Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах 3-5 настай хүүхдийн хамран сургалтын хувь | 62.6 | 88.5 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| | | | Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх 5 настай хүүхдийн хувь | 91.3 | 96.7 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| 1.1.5 | МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.9 | Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах | Ашиглалтад орох сургуулийн тоо | 17 сургууль | 36 сургууль | 279,713.8 | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Ашиглалтад орох цэцэрлэгийн тоо | 28 цэцэрлэг | 48 цэцэрлэг | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.6 | МУХТЖҮЧ-2.1.8, ЗГҮАХ-2.3.4, 2.3.9, 2.3.11 | Суралцагч тухтай орчинд суралцаж, бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх | Сургууль, цэцэрлэгийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлын явц, хувиар | - | 100 | 10,880.0 | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| | | | Ашиглалтад оруулах дотуур байрны тоо | - | 17 | 34,136.2 | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Шинээр барих болон өргөтгөх спорт заалны тоо | - | 19 | 17,216.6 | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдах суралцагчийн хувь | - | 50 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| | | | Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах цэцэрлэг, сургууль, дотуур байрны тоо | - | 139 сургууль, 83 цэцэрлэг, 112 дотуур байр | - | Дотоодын хөрөнгө оруулалт | Боловсрол, шинжлэх ухааны яам | Барилга, хот байгуулалтын яам, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 1.1.7 | МУХТЖҮЧ-2.1.9, ЗГҮАХ-2.3.10 | Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, эрүүл ахуйн стандартыг дээшлүүлж, “Үдийн хоол” хөтөлбөрт дунд ангийн сурагчдыг нэмж хамруулах | Стандартад нийцсэн хоолны газартай сургуулийн эзлэх хувь | 25 | 100 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | Эрүүл мэндийн яам |
| | | | “Үдийн хоол” хөтөлбөрт хамрагдах дунд ангийн сурагчийн тоо | - | 194,833 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| 1.1.8 | МУХТЖҮЧ-2.1.5, ЗГҮАХ-1.1.11, 2.3.8 | Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч, багш мэргэжлээр суралцагчид | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сурлагын амжилттай нь уялдуулан тэтгэлэг олгох | | | | | | | |
| **Зорилго 1.2.Судалгаа хөгжүүлэлт, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлнэ.** | | | | | | | | | |
| 1.2.1 | МУХТЖҮЧ-2.4.1, ЗГҮАХ-2.4.1 | Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгааны ажлыг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлэх | Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардал, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар | 0.1 | 0.18 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | Сангийн яам |
| | | | Инновацын тэргүүлэх чиглэлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи, судалгаа хөгжүүлэлтийг дэмжих ажлын явц, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| 1.2.2 | МУХТЖҮЧ-2.4.3, ЗГҮАХ-2.4.2 | Эрдэм шинжилгээний байгууллагуудын нэгдмэл байдлыг хангах, уялдаа холбоог сайжруулах | Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлын явц, хувиар | - | 100 | 50,378.8 | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| **Зорилго 1.3.Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | | | |
| 1.3.1 | МУХТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.1 | Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 30 | - | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 50 | - | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 50 | - | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах ажлын явц, хувиар | - | 50 | - | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 30 | - | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | “Хавдрын эсрэг” арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 50 | - | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 1.3.2 | МУХТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-1.1.3, 2.1.3 | Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах | Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар | - | 20 | 16,500.0 | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |
| | | | Зүрх судасны төвийн барилгын ажлын явц, хувиар | - | 10 | 10,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |
| | | | Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын ажлын явц, хувиар | - | 10 | 40,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |
| | | | Геронтологийн төвийн барилгын ажлын явц, хувиар | 46 | 80 | 5,600.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |
| | | | Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II-ын барилгын ажлын явц, хувиар | - | 10 | 60,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |
| | | | Хавдар судлалын үндэсний төвийн салбар II-ын барилгын ажлын явц, хувиар | - | 10 | 30,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Баянзүрх дүүрэг дэх 300 ортой эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар | - | 20 | 5,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |
| | | | Шинээр барих болон өргөтгөх нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн тоо | - | 40 | 113,624.5 | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Өвчний хяналт, зохицуулалтын төвийн барилгын ажлын явц, хувиар | - | 100 | 1,500.0 | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |
| 1.3.3 | МУХТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-2.1.6 | Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, нэгдсэн сан бүхий мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх | Мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 30 | 100 | 18,138.0 | Гадаадын зээл, тусламж | Эрүүл мэндийн яам | |
| | | | Телемедицин нэвтрэх эрүүл мэндийн байгууллагын тоо | 3 | 35 | - | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | Сангийн яам |
| 1.3.4 | МУХТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.14 | Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг орчин үеийн стандартад нийцүүлэн шинэчлэх | Ариун цэврийн байгууламжийг шинэчлэх сумын эрүүл мэндийн төвийн тоо | 15 | 60 | 11,160.0 | Улсын төсөв | Эрүүл мэндийн яам | |
| **Зорилго 1.4.Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| 1.4.1 | МУХТЖҮЧ-3.5.2, ЗГҮАХ-2.2.3 | Олон улсын жишигт нийцсэн спорт цогцолборыг ашиглалтад оруулж, хүн амын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих | Ашиглалтад орох спортын ордон болон цогцолборын тоо | - | 14 | 75,320.9 | Улсын төсөв | Биеийн тамир, спортын улсын хороо | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.4.2 | МУХТЖҮЧ-2.3.2, ЗГҮАХ-2.5.8 | Хүүхдийн хөгжлийг дэмжих “Найрамдал-2” зуслангийн цогцолбор барих | Барилгын ажлын явц, хувиар | - | 40 | 24,000.0 | Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Сангийн яам |
| 1.4.3 | МУХТЖҮЧ-1.2.4, ЗГҮАХ-2.5.8 | Ахмад настан, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төвийг байгуулах | Ашиглалтад орох хөгжлийн төвийн тоо | - | 10 | 23,632.2 | Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | |
| **Зорилго.1.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүч бэлтгэж, ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглүүлж, халамжаас хөдөлмөрт шилжих оновчтой бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 1.5.1 | МУХТЖҮЧ-2.6.2, ЗГҮАХ-2.5.4 | Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, эрэлт, хэрэгцээтэй уялдуулан дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх | Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, эрэлт, хэрэгцээний чиглэлээр хийх судалгааны тоо | - | 3 | - | Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| | | | Ажил мэргэжлийн эрэлтэд суурилан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| 1.5.2 | МУХТЖҮЧ-2.3.4, 2.6.2, ЗГҮАХ-2.3.12, 2.5.8, 2.5.9 | Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | Орлого багатай иргэдэд чиглэсэн мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Сангийн яам, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Залуучуудад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөрт бэлтгэх, ажлын байранд дадлагажуулах арга | - | 100 | - | Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээний хэрэгжилт, хувиар | | | | | | |
| | | | Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилгын ажлын явц, хувиар | 20 | 100 | 16,788.7 | Гадаадын зээл, тусламж | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| | | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх Хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилгын ажлын явц, хувиар | - | 50 | 17,279.5 | Гадаадын зээл, тусламж | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Сангийн яам |
| | | | Насан туршдаа суралцах боломжийг дэмжих, бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг баталгаажуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Боловсрол, шинжлэх ухааны яам | |
| 1.5.3 | МУХТЖҮЧ-3.3.2, ЗГҮАХ-3.3.13 | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхлэгчдэд ажлын байр бий болгох, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх | Дэмжлэгт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхлэгчдийн тоо | 12 | 400 | - | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Сангийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5.4 | МУХТЖҮЧ-4.5.2, ЗГҮАХ-3.3.14 | Үндэсний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх, чадавхжуулах “Үндэсний ханган нийлүүлэлт” арга хэмжээг хэрэгжүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Эдийн засаг, хөгжлийн яам | |
| 1.5.5 | МУХТЖҮЧ-3.1.5, ЗГҮАХ-2.5.5 | Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Сангийн яам |
| **Зорилго 1.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 1.6.1 | МУХТЖҮЧ-1.2.1, 1.5.1, 4.2.4, ЗГҮАХ-2.6.2, 4.5.10 | Үндэсний бахархал, өв соёлыг сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих | “Соёлын бүтээлч үйлдвэрлэл-I” арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 50 | 80 | - | Улсын төсөв | Соёлын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын барилгын ажлын явц, хувиар | 50 | 100 | 4,000.0 | Улсын төсөв | Соёлын яам | Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам |
| | | | “Дэлхийн монголчууд II” цогц арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 70 | - | Улсын төсөв | Гадаад харилцааны яам | Соёлын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам |
| | | | Ашиглалтад орох соёл урлагийн байгууламж, музей болон номын сангийн тоо | - | 15 | 71,085.7 | Улсын төсөв | Соёлын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Бүлэг 2.Эдийн засгийн бодлого** | | | | | | | | | |
| **Зорилго 2.1.Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, өрийн менежментийг сайжруулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангана.** | | | | | | | | | |
| 2.1.1 | МУХТЖҮЧ-4.1.5, ЗГҮАХ-3.1.1 | Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах мөнгөний бодлого хэрэгжүүлэх | Инфляцын түвшин, хувиар | 13.4 | 6±2 | - | Улсын төсөв | Монголбанк | Сангийн яам |
| 2.1.2 | МУХТЖҮЧ-4.1.1, 4.1.2, ЗГҮАХ-3.1.2, 3.1.9 | Засгийн газрын өрийн хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаараас хэтрүүлэхгүй байхад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх | Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэх Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 50.7 | 65 хувиас хэтрэхгүй | - | Улсын төсөв | Сангийн яам | |
| | | | Засгийн газрын гадаад өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 60.7 | 60 хувиас хэтрэхгүй | - | Улсын төсөв | Сангийн яам | |
| | | | Төсвийн алдагдлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь | 5.1 | 3.6 | - | Улсын төсөв | Сангийн яам | |
| 2.1.3 | МУХТЖҮЧ-4.1.2, ЗГҮАХ-4.3.12 | Санхүүгийн зах зээлийг өргөжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо | |
| 2.1.4 | МУХТЖҮЧ-4.1.2, ЗГҮАХ-5.1.12 | Тогтвортой санхүүжилт болон ногоон төслүүдийг дэмжих тогтолцоог бүрдүүлж, хөгжлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 2.2.Боомтын сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэн эдийн засгийн өсөлтийг тэтгэж, экспортыг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 2.2.1 | МУХТЖҮЧ-8.1.5, ЗГҮАХ-3.1.18, 4.3.1 | Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барих | Хилийн боомтуудыг орчин үеийн технологи бүхий хяналт шалгалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувиар | - | 100 | 63,595.9 | Улсын төсөв | Сангийн яам | |
| | | | Шивээхүрэн боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажлын явц, хувиар | - | 100 | 70,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Сангийн яам | |
| | | | Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн дэд бүтэц, барилгын ажлын явц, хувиар | - | 100 | 12,523.4 | Гадаадын зээл, тусламж | Эдийн засаг, хөгжлийн яам | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Хүний биеийн давхцахгүй өгөгдөлд тулгуурласан шинээр суурилуулах ухаалаг гарцын тоо | Чингис хаан боомт-12 | Алтан-булаг-8, Замын-Үүд-8, Бичигт-4, Боршоо-4 | - | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | |
| 2.2.2 | МУХТЖҮЧ-8.1.2, ЗГҮАХ-3.6.1 | Боомтуудыг холбох төмөр зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх | Тавантолгой-Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 50 | 232,526.5 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам |
| | | | Баруун-Урт-Бичигт чиглэлийн 277.3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 30 | 332.7 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам |
| | | | Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478 км | 17 | 100 | 474,154.8 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн | Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар | | | | | хөгжлийн яам | |
| | | | Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замын барилгын ажлын явц, хувиар | 18 | 100 | 238,600.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам |
| | | | Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 30 | 33,844.3 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам |
| | | | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар | 24 | 100 | 890,320.7 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яам |
| | | | Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 22,750.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам |
| | | | Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 36,360.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн хөгжлийн яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 75,600.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам |
| **Зорилго 2.3.Эрчим хүчний сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд эрчим хүчний найдвартай, тогтвортой эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг шинээр барьж байгуулна.** | | | | | | | | | |
| 2.3.1 | МУХТЖҮЧ-4.2.7, ЗГҮАХ-3.5.1 | Эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх | Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийг байгуулах барилгын ажлын явц, хувиар | - | 20 | 142,500.0 | Дотоодын хөрөнгө оруулалт | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| | | | Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг өргөтгөх барилгын ажлын явц, хувиар | 58 | 100 | 15,708.0 | Монгол Улсын Хөгжлийн банк | Эрчим хүчний яам | |
| | | | Амгалангийн дулааны станцыг өргөтгөх барилгын ажлын явц, хувиар | - | 80 | 35,750.0 | Монгол Улсын Хөгжлийн банк | Эрчим хүчний яам | |
| | | | Багануурын цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар | 5 | 40 | 611,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрчим хүчний яам | |
| | | | Дулааны II цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станц барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 85,380.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрчим хүчний яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Дулааны III цахилгаан станцыг 325 МВт-аар өргөтгөх төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 146,740.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрчим хүчний яам | |
| | | | Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа дулаан, цахилгааны хэрэгцээг хангах шинэ эх үүсвэр байгуулах төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 750.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| | | | Төвлөрсөн хот, сум, суурин газарт эрчим хүчний эх үүсвэр шинээр барих, өргөтгөх үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100 | 157,165.7 | Улсын төсөв | Эрчим хүчний яам | |
| 2.3.2 | МУХТЖҮЧ-4.2.8, ЗГҮАХ-3.5.1, 3.5.6 | Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах цэвэр эрчим хүчний ногоон төслүүдийг хэрэгжүүлэх | Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар | - | 20 | 115,000.0 | Гадаадын зээл, тусламж | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| | | | 160 МВт.ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих ажлын явц, хувиар | 10 | 100 | 45,000.0 | Гадаадын зээл, тусламж | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| | | | Ашиглалтад орох сэргээгдэх эрчим хүчний 10 МВт-ын станцын тоо | - | 3 | 42,504.2 | Гадаадын зээл, тусламж | Эрчим хүчний яам | Сангийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.3 | МУХТЖҮЧ-4.2.8, ЗГҮАХ-3.1.17, 3.5.4 | Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэн алдагдлыг бууруулж, суурин газруудыг холбох | Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн 35 кВт-ын цахилгаан дамжуулах шугам барих ажлын явц, хувиар | - | 100 | 7,317.1 | Улсын төсөв | Эдийн засаг, хөгжлийн яам | Сангийн яам |
| | | | Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын явц, хувиар | - | 30 | 180,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| | | | Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах "Эрчим хүчний төсөл-2" төслийн хэрэгжилт, хувиар | 70 | 100 | 22,694.3 | Гадаадын зээл, тусламж | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| | | | Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн хэрэгжилт, хувиар | 8 | 60 | 13,000.0 | Гадаадын зээл, тусламж | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| 2.3.4 | МУХТЖҮЧ-4.2.12, ЗГҮАХ-3.5.3 | Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх | Шинээр 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв барих ажлын явц, хувиар | 15 | 70 | 83,000.0 | Гадаадын зээл, тусламж | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| | | | Хан-Уул, Баянгол дүүрэгт хэрэгжих "Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл"-ийн хэрэгжилт, хувиар | 10 | 60 | 31,000.0 | Гадаадын зээл, тусламж | Эрчим хүчний яам | Сангийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүрэгт хэрэгжих “Улаанбаатарын дулаан хангамж төсөл”-ийн хэрэгжилт, хувиар | 30 | 70 | 22,811.5 | Гадаадын зээл, тусламж | Эрчим хүчний яам | Сангийн яам |
| **Зорилго 2.4.Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | | |
| 2.4.1 | МУХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ-3.2.7, 3.2.8 | Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг түүхий эдийг боловсруулах хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх | Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар | 50 | 90 | 200,000.0 | Гадаадын зээл, тусламж | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| | | | Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 10 | 90 | 330,000.0 | Гадаадын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| | | | “Алтанширээт аж үйлдвэрийн парк”-ийн барилгын явц, хувиар | - | 75 | 912,000.0 | Дотоодын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| | | | Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах барилгын явц, хувиар | - | 45.4 | 656,177.5 | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| | | | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэл хийх барилгын ажлын явц, хувиар | 69.4 | 100 | 139,020.4 | Дотоодын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” барих ажлын явц, хувиар | - | 100 | 133,663.0 | Дотоодын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| | | | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлын явц, хувиар | - | 50 | 146,556.0 | Дотоодын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| | | | | | | 341,964.0 | Гадаадын хөрөнгө оруулалт | | |
| | | | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр барих ажлын явц, хувиар | - | 100 | 167,371.0 | Дотоодын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| 2.4.2 | МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.1 | Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх | Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 7 | 21 | 587,200.0 | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| | | | Конвейерийн систем нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 3 | 43 | | | | |
| | | | Нүүрс ачилтын нэгдсэн төв байгуулах ажлын явц, хувиар | 28 | 80 | | | | |
| | | | Нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн ажлын явц, хувиар | 10 | 80 | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.4.3 | МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.1 | Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой ордын далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх | Бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 78 | 89 | 2,225,850.0 | Гадаадын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | |
| 2.4.4 | МУХТЖҮЧ-3.2.4, ЗГҮАХ-3.7.13 | Арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн түүхий эдийг дотооддоо үйлдвэрлэх барилгын материалын үйлдвэрүүд барих | Ашиглалтад орох үйлдвэрийн тоо | - | 7 | 86,894.5 | Дотоодын хөрөнгө оруулалт | Барилга, хот байгуулал-тын яам | |
| 2.4.5 | МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.3 | Геологийн зураглал, судалгааны ажлыг эрчимжүүлэн, гео мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, үйлчилгээг цахимжуулах | Геологийн 1:50000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар | 41.9 | 46 | - | Улсын төсөв | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Үндэсний геологийн алба |
| | | | Геологийн 1:25000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар | - | 0.1 | - | Улсын төсөв | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Үндэсний геологийн алба |
| | | | Геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг хийх талбайн хэмжээ, хувиар | 68 | 100 | - | Улсын төсөв | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Үндэсний геологийн алба |
| | | | Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгаа бүхий нутаг дэвсгэрийн хэмжээ, хувиар | 65 | 68.1 | - | Улсын төсөв | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Үндэсний геологийн алба |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Геологийн зураглалыг төрөлжүүлж, шинээр болон үргэлжлүүлэн хийх судалгааны ажлын тоо | 15 | 24 | - | Улсын төсөв | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Үндэсний геологийн алба |
| | | | Мэдээллийн баяжуулалт хийж, үйлчилгээг цахимжуулах гео мэдээллийн нэгдсэн сангийн тоо | - | 3 | - | Улсын төсөв | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Үндэсний геологийн алба |
| **Зорилго 2.5.Хөдөө аж ахуйн гол нэрийн 19 бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд суурилсан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 2.5.1 | МУХТЖҮЧ-4.2.4, ЗГҮАХ-3.3.10 | Малын гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулах | “Шинэ Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 10 | 100 | 13,430.0 | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Аймгийн-Засаг даргын Тамгын газар, ““Шинэ Ховд” баруун бүсийн хөгжлийн корпорац” ОНӨААТҮГ |
| | | | “Дархан арьс ширний цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | - | 70 | 107,000.0 | Гадаадын хөрөнгө оруулалт | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Аймгийн-Засаг даргын Тамгын газар, “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК |
| 2.5.2 | МУХТЖҮЧ-8.3.1, ЗГҮАХ-3.3.3 | Дотоодын мах, сүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, хүн амын хэрэгцээнд зориулан нөөц бүрдүүлэх | Сэрүүний улиралд нийлүүлэх түүхий сүүний хэмжээ, сая литр | 16.8 | 24.5 | - | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |
| | | | Ашиглалтад орох сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах | - | 9 | 6,119.4 | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлдвэр, фермийн тоо | | | | | | |
| | | | Нөөцөлж, борлуулах махны хэмжээ, мянган тонн | 10 | 15 | - | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |
| 2.5.3 | МУХТЖҮЧ-8.3.5, ЗГҮАХ-3.3.8 | Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, малын гоц халдварт өвчнийг бууруулах | Мал, амьтны халдварт өвчин /гоц халдварт болон зооноз өвчнөөс бусад/-ий голомт, тохиолдлын бууралт, хувиар | - | 2 | - | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |
| | | | Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |
| | | | Малын бруцеллёз, боом, галзуу зэрэг зооноз өвчний халдварын бууралт, хувиар | - | 2 | - | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |
| 2.5.4 | МУХТЖҮЧ-8.3.11, ЗГҮАХ-3.3.1 | Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих | Усалгаатай талбайн хэмжээ, мянган га | 56 | 63 | 18,000.0 | Гадаадын зээл, тусламж | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Сангийн яам |
| | | | | | | 2,150.0 | Улсын төсөв | | |
| 2.5.5 | МУХТЖҮЧ-8.3.6, ЗГҮАХ-3.3.1 | Газар тариалангийн үр ашгийг нэмэгдүүлэх, үр тариа хадгалах элеватор байгуулах | Бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ашиглалтад оруулах үр тариа, хүнсний ногооны агуулах, зоорины тоо | - | 2 | 3,700.0 | Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | |
| **Зорилго 2.6.Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 2.6.1 | МУХТЖҮЧ-1.1.2, 1.1.4, ЗГҮАХ-2.6.1 | Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх | “Чингис хаан” хаад, язгууртны шинэ музейн тохижилтын ажлын явц, хувиар | 90 | 100 | 10,107.0 | Улсын төсөв | Соёлын яам | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Байгалийн түүхийн шинэ музейн барилгын ажлын явц, хувиар | 30 | 40 | 36,097.6 | Улсын төсөв | Соёлын яам | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Улсын драмын эрдмийн театрын барилгын хүчитгэлийн ажлын явц, хувиар | 60 | 100 | 1,186.7 | Улсын төсөв | Соёлын яам | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Үндэсний номын сангийн барилга угсралтын ажлын явц, хувиар | 85 | 100 | 7,400.0 | Улсын төсөв | Соёлын яам | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Үндэсний археологи, угсаатны зүйн музей, лабораторийн барилга угсралтын ажлын явц, хувиар | 20 | 40 | 7,850.0 | Улсын төсөв | Соёлын яам | Барилга, хот байгуулалтын яам |
| 2.6.2 | МУХТЖҮЧ-8.2.3, ЗГҮАХ-3.4.1 | “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I, II”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I”-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | 30 | 70 | 29,000.0 | Гадаадын зээл, тусламж | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Аймгийн Засаг даргын Тамгын газар |
| | | | “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл II”-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | - | 30 | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.3 | МУХТЖҮЧ-8.2.1, ЗГҮАХ-3.4.4, 3.4.7, 3.4.8, 4.5.10 | Цар тахлын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, сурталчилгааг идэвхжүүлэх | Аялал жуулчлалын салбарыг дэмжиж, жуулчдыг татах чиглэлээр хэрэгжүүлэх төслийн хэрэгжилт, жуулчдын тоо | 33,000 | 400,000 | - | Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | |
| | | | “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 70 | - | Улсын төсөв | Гадаад харилцааны яам | |
| | | | “FeelMongolia” аялал жуулчлалын цахим сурталчилгааны хэрэгжилт, хандалтын өсөлтийн хувиар | - | 20 | - | Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | |
| 2.6.4 | МУХТЖҮЧ-8.1.3, ЗГҮАХ-3.4.6 | Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу түр зогсох цэгийг 100 км тутамд барьж байгуулах | Шинээр байгуулах түр зогсох цэгийн тоо | 1 | 10 | 18,000.0 | Дотоодын хөрөнгө оруулалт | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| **Бүлэг 3.Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого** | | | | | | | | | |
| **Зорилго 3.1.Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн зөвшилцөлд үндэслэсэн түншлэлийн тогтолцоог хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 3.1.1 | МУХТЖҮЧ-5.3.2, 5.3.4, ЗГҮАХ-3.1.11, 4.1.1, 4.1.3, 4.5.1, 4.5.3 | Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх | Татварын тайлагналт, хураалтыг цахимжуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Сангийн яам | Татварын ерөнхий газар |
| | | | Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 50 | - | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | Улсын бүртгэлийн ерөнхий газар |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | “Цахим архив, албан хэрэг хөтлөлт” арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 30 | - | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | Архивын ерөнхий газар |
| | | | “Цахим нэг цонхны үйлчилгээ”-ээр олгох гадаадын хөрөнгө оруулалтын үйлчилгээний тоо | 6 | 16 | - | Улсын төсөв | Эдийн засаг, хөгжлийн яам | Холбогдох бусад |
| | | | Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/ суурилуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| | | | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 12,900.0 | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | Архивын ерөнхий газар |
| | | | Цахим виз олгох улсын тоог нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яам | Гадаадын иргэн, харьяатын газар |
| 3.1.2 | МУХТЖҮЧ-2.6.5, ЗГҮАХ-2.5.4, 2.5.5, 4.2.10 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн албан хаагчдын цалин хөлсний | Инфляцын түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Сангийн яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | системийг бүтээмж, ажлын үр дүнтэй уялдуулан шинэчилж, цалин хөлсийг нэмэгдүүлэх | Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшууллалтай уялдуулах гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн систем нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Төрийн албаны зөвлөл | Холбогдох бусад |
| 3.1.3 | МУХТЖҮЧ-5.6.2, ЗГҮАХ-4.2.1 | Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Авлигатай тэмцэх газар | Холбогдох бусад |
| 3.1.4 | МУХТЖҮЧ-5.4.5, ЗГҮАХ-4.2.1 | Зарим төрлийн төрийн хяналт шалгалтыг зогсоож, зөвлөн туслах эрх зүйн орчныг бүрдүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | |
| 3.1.5 | МУХТЖҮЧ-4.2.5, ЗГҮАХ-4.1.5 | Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх | Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төслийн хэрэгжилт, хувиар | - | 20 | 19,000.0 | Гадаадын зээл, тусламж | Сангийн яам | Холбогдох бусад |
| | | | Шинээр үүрэн холбооны дамжуулах сүлжээнд холбох суурин газрын тоо | - | 5 | 6,253.8 | Улсын төсөв | Цахим хөгжил, харилцаа холбооны яам | Холбогдох бусад |
| **Зорилго 3.2. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.** | | | | | | | | | |
| 3.2.1 | МУХТЖҮЧ-7.2.3, ЗГҮАХ-4.3.1 | Улсын хил хамгаалах салбарын байгууламжийн шинэтгэл хийж, техник технологийн | Улсын хил хамгаалалтын зориулалтын инженер, техникийн байгууламжийг шинэчлэх ажлын явц, хувиар | - | 100 | 6,886.2 | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | Хил хамгаалах ерөнхий газар |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүчин чадлыг нэмэгдүүлэх | Төвлөрсөн эрчим хүчинд холбогдох хилийн салбарын тоо | - | 2 | 1,750.0 | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | Хил хамгаалах ерөнхий газар |
| 3.2.2 | МУХТЖҮЧ-7.4.1, ЗГҮАХ-4.3.2 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох тогтолцоог бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | Камерын хяналтын төв байгуулах аймгийн тоо | - | 10 | - | Гадаадын зээл, тусламж | Хууль зүй, дотоод хэргийн яам | Цагдаагийн ерөнхий газар |
| | | | Хууль сахиулах байгууллагын шинэчлэх барилгын тоо | - | 14 | 26,022.0 | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | |
| 3.2.3 | МУХТЖҮЧ-6.4.3, ЗГҮАХ-4.3.11 | Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг бэхжүүлэх хүрээнд аврах ажиллагаа явуулах нөхцөлийг сайжруулах | Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хэрэгжилт, хувиар | 50 | 80 | 19,000.0 | Гадаадын зээл, тусламж | Шадар сайд | Онцгой байдлын ерөнхий газар |
| 3.2.4 | МУХТЖҮЧ-6.3.1, ЗГҮАХ-4.3.2 | Дулааны цахилгаан станц, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг дотоодын цэргийн хамгаалалтад авах | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам | |
| **Зорилго 3.3.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан, мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 3.3.1 | МУХТЖҮЧ-7.1.1, ЗГҮАХ-4.6.4 | Барилга-инженерийн цэргийн ангийг шинээр байгуулах | Байгуулах ангийн тоо | - | 2 | - | Улсын төсөв | Батлан хамгаалах яам | Зэвсэгт хүчний Жанжин штаб |
| 3.3.2 | МУХТЖҮЧ-7.1.4, ЗГҮАХ-4.6.7 | Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, технологи, инновацыг нэвтрүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 10 | 35 | - | Улсын төсөв | Батлан хамгаалах яам | Зэвсэгт хүчний Жанжин штаб |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Бүлэг 4.Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого** | | | | | | | | | |
| **Зорилго 4.1.Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| 4.1.1 | МУХТЖҮЧ-6.2.5, ЗГҮАХ-5.1.5 | Ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих, ойн хомстол, доройтлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулах талбайн хэмжээ, мянган га | 4.9 | 9 | - | Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Аймгийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Ойн хөнөөлт шавж, өвчний голомттой тэмцэх талбайн хэмжээ, мянган га | 33.9 | 150 | | | | |
| | | | Ой зохион байгуулалт хийх талбайн хэмжээ, мянган га | 1,600 | 1,800 | | | | |
| | | | Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мянган га | 32 | 36 | | | | |
| 4.1.2 | МУХТЖҮЧ-6.3.2, ЗГҮАХ-5.1.11 | Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх | Онги, Хэрлэн усан цогцолбор барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 905,000.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам |
| 4.1.3 | МУХТЖҮЧ-6.2.4, ЗГҮАХ-5.1.8 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх | Нөхөн сэргээх талбайн хэмжээ, мянган га | - | 2 | 40,000.0 | Дотоодын хөрөнгө оруулалт | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.4 | МУХТЖҮЧ-6.2.1, ЗГҮАХ-5.1.5 | Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах | Цөлжилтийг сааруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талбайн хэмжээ, га | 200 | 400 | 1,290.0 | Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 4.1.5 | МУХТЖҮЧ-6.3.3, ЗГҮАХ-5.1.3 | Хүн амын унд, ахуйн ус хангамжийн нөөц тогтоох хайгуул судалгаа хийх | Нөөц тогтоох сумын төвийн тоо | 2 | 5 | 1,800.0 | Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 4.1.6 | МУХТЖҮЧ-6.3.1, ЗГҮАХ-5.1.2 | Хөвсгөл нуурт живсэн машин техникийг татаж гаргах | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 20 | 60 | - | Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Онцгой байдлын ерөнхий газар, Усны газар |
| 4.1.7 | МУХТЖҮЧ-2.5.3, 9.2.1, ЗГҮАХ-5.1.1 | Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | Агаар дахь PM 2.5, PM10 тоосонцрын агууламжийн хэмжээ, мкг/м3 | PM 2.5-44 мкг/м3, PM10-89 мкг/м3 | PM 2.5-39 мкг/м3, PM10-78 мкг/м3 | - | Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Холбогдох бусад |
| 4.1.8 | МУХТЖҮЧ-6.4.2, ЗГҮАХ-5.1.12 | Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилгын хэрэгжилтийг хангах | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Холбогдох бусад |
| **Бүлэг 5.Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого** | | | | | | | | | |
| **Зорилго 5.1.Хот, хөдөөгийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, амьдрах таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 5.1.1 | МУХТЖҮЧ-9.3.2, ЗГҮАХ-3.7.9, 6.1.3 | Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг | “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн | 10 | 100 | - | Орон нутгийн төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх | бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар | | | 252,658.5 | Гадаадын зээл, тусламж | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | |
| | | | “Орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл” төслийн явц, хувиар | - | 30 | 36,728.0 | Гадаадын зээл, тусламж | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | “Залуус-1” орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар | - | 10 | 11,980.0 | Улсын төсөв | Барилга, хот байгуулал-тын яам | Холбогдох бусад |
| | | | “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийн явц, хувиар | - | 70 | 37,826.8 | Гадаадын зээл, тусламж | Барилга, хот байгуулал-тын яам | |
| | | | “Солонго-1”, “Солонго-2” орон сууцны хороолол барих төслийн явц, хувиар | - | 50 | 10,000.0 | Гадаадын зээл, тусламж | Барилга, хот байгуулал-тын яам | |
| 5.1.2 | МУХТЖҮЧ-2.5.2, ЗГҮАХ-3.7.10 | Бага, дунд орлоготой иргэдийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах | Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэдийн тоо | 13,292 | 30,476 | 900,000.0 | Бусад | Барилга, хот байгуулал-тын яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 5.1.3 | МУХТЖҮЧ-9.5.1, ЗГҮАХ-3.5.7 | Шинэ суурьшлын бүс, чөлөөт бүсийн хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, дэд | Хөшигийн хөндийн “Шинэ Зуунмод” хотын төлөвлөлтийн хүрээнд боловсруулах | 1 | 3 | - | Улсын төсөв | Барилга, хот байгуулал-тын яам | Холбогдох бусад |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх | хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө | | | | | | |
| | | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэн, зураг төслийг боловсруулах объектын тоо | - | 94 | 16,172.5 | Улсын төсөв | Барилга, хот байгуулал-тын яам | |
| | | | “Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийн явц, хувиар | - | 10 | 15,300.0 | Улсын төсөв | Барилга, хот байгуулал-тын яам | Холбогдох бусад |
| 5.1.4 | МУХТЖҮЧ-9.3.4, ЗГҮАХ-6.1.6 | Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | Арга хэмжээний хэрэгжилт, хувиар | 10 | 100 | 420,000.0 | Орон нутгийн төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Зам, тээврийн хөгжлийн яам |
| 5.1.5 | МУХТЖҮЧ-2.5.6, 9.3.3, ЗГҮАХ-6.1.10 | Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх | Улаанбаатар хотын ус хангамжийг урт хугацаанд тогтвортойгоор нэмэгдүүлэх төслийн явц, хувиар | 15 | 45 | 369,000.0 | Гадаадын зээл, тусламж | Барилга, хот байгуулал-тын яам | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төслийн явц, хувиар | 40 | 90 | 108,000.0 | Гадаадын зээл, тусламж | Барилга, хот байгуулал-тын яам | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Улаанбаатар хотын инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар | - | 100 | 3,106.5 | Улсын төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Барилга, хот байгуулалтын яам |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.6 | МУХТЖҮЧ-9.2.4, ЗГҮАХ-6.1.7 | Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдрах орчныг сайжруулах | Хот доторх авто зам шинээр барих, өргөтгөх ажлын явц, хувиар | - | 100 | 9,192.1 | Улсын төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Шинээр барих дугуйн зам, км | - | 30 | - | Орон нутгийн төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Шинээр барих явган хүний зам, м2 | - | 150,000 | - | Орон нутгийн төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Барилга, хот байгуулалтын яам |
| | | | Гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар | - | 100 | 41,098.7 | Улсын төсөв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Барилга, хот байгуулалтын яам |
| **Зорилго 5.2.Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.** | | | | | | | | | |
| 5.2.1 | МУХТЖҮЧ-8.1.10, 9.3.3, ЗГҮАХ-3.7.11, 6.2.7 | Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх | Аймгийн төв, суурин газрын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн явц, хувиар | 10 | 80 | 22,000.0 | Гадаадын зээл, тусламж | Барилга, хот байгуулал-тын яам | |
| | | | “Сумын хөгжил” арга хэмжээний хүрээнд инженерийн дэд бүтэц байгуулах сумын тоо | 5 | 18 | 31,800.0 | Улсын төсөв | Барилга, хот байгуулал-тын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар | - | 100 | 130,772.6 | Улсын төсөв | Барилга, хот байгуулал-тын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох ажлын явц, хувиар | - | 100 | - | Улсын төсөв | Барилга, хот байгуулал-тын яам | |
| 5.2.2 | МУХТЖҮЧ-8.1.11, ЗГҮАХ-3.6.1, 3.6.2 | Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих авто зам барих төслүүдийг хэрэгжүүлэх | Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын барилгын ажлын явц, хувиар | 26.5 | 100 | 85,500.0 | Гадаадын зээл, тусламж | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам |
| | | | Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 121 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 30 | 30,220.0 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам |
| | | | Жаргалтхаан-Өмнөдэлгэр-Рашаан хад-Өглөгчийн хэрэм-Биндэр-Баян-Адарга-Дадал чиглэлийн 290 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 30 | 50,910.0 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |
| | | | Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн 90.1 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 30 | 15,000.0 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |
| | | | Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн 63 км авто замын барилгын ажлын явц, хувиар | 24 | 100 | 36,890.3 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл 99.7 км авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 30 | 23,546.0 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |
| | | | Чингис-Норовлин-Дадал чиглэлийн 255 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 50 | 31,376.3 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |
| | | | Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийг замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто зам барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар | - | 100 | 77,122.0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | Зам, тээврийн хөгжлийн яам | Сангийн яам |
| | | | Хялганат-Хангал чиглэлийн эхлэлийн хатуу хучилттай 10 км авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 100 | 2,000.0 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |
| | | | Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай 122.4 км авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 25 | 33,620.9 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 100 | 9,375.3 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |
| | | | Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх хатуу хучилттай 56.9 км авто замын барилгын ажлын явц, хувиар | - | 100 | 34,339.0 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |
| 5.2.3 | МУХТЖҮЧ-8.1.10, 9.3.4, ЗГҮАХ-6.2.7 | Сум, суурин доторх авто зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах | Сум, суурин доторх авто зам шинээр барих, өргөтгөх ажлын явц, хувиар | - | 100 | 165,161.7 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |
| | | | Сум, суурин доторх гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар | - | 100 | 52,787.4 | Улсын төсөв | Барилга, хот байгуулалтын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| | | | Аймгийн төвүүдэд байгуулах зорчигч тээврийн авто буудлын тоо | - | 1 | 3,000.0 | Улсын төсөв | Зам, тээврийн хөгжлийн яам | |

Товчилсон үгийн жагсаалт:

МУХТЖҮЧ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
ЗГҮАХ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

---oOo---

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 31 | Улаанбаатар хот

## Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.3 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2022 онд төлөвлөсөн 18.0 сая тонн нүүрс экспортлохоос 2022 оны эхний 4 сарын байдлаар 3.8 сая тонн нүүрс экспортолж, төлөвлөж байсан экспорт саатаж, нүүрсний экспортоос улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн 1.3 их наяд төгрөгийн орлого тасалдах нөхцөл байдал үүссэнийг, түүнчлэн Монгол Улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн зардал хэт өссөн, үүнтэй холбогдон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг тогтоох шаардлагыг тус тус үндэслэн Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулсугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох”-оор тогтоосугай.

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/Ханги, Байтаг, Замын-Үүд, Гашуун сухайт, Булган, Бичигт, Шивээ хүрэн боомтын нүүрс нэвтрүүлэх болон Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт бүсийн үйл ажиллагаа;

2/боомт, чөлөөт бүсийн үйл ажиллагаанд оролцож байгаа мэргэжлийн хяналт, гааль, хил хамгаалах, цагдаа, хилийн боомтын үндэсний зөвлөл, хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа, чөлөөт бүсийн захирагч зэрэг төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагаа, тэдгээрийн уялдаа холбоо;

3/боомтод үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа;

4/боомт, хилийн бүс дэх газар олголт, газар ашиглалт болон гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа;

5/нүүрсний тээвэр логистик /хилээр нэвтрэх төмөр зам, авто тээвэр, тээврийн хэрэгслийн зардлын өсөлт/;

6/экспортод гаргаж байгаа нүүрсний гаалийн бүрдүүлэлт;
7/уул уурхайн салбарт төр болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн нүүрс экспортлохтой холбоотой гэрээний эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн худалдааны үнэ тарифын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал;

8/чөлөөт бүсэд нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулахтай холбоотой эрх зүйн орчны болон төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа.

4.Энэ тогтоолын 3 дахь заалтад заасан тусгай шалгалтын үр дүнг үндэслэн нүүрсний экспортыг сайжруулахтай холбоотой тодорхой саналыг Улсын Их Хуралд танилцуулсугай.

5.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Олонхыг төлөөлөн:**

| | |
|---|---|
| Ц.Анандбазар | Улсын Их Хурлын гишүүн |
| Б.Баттөмөр | Улсын Их Хурлын гишүүн |
| Г.Ганболд | Улсын Их Хурлын гишүүн |
| Л.Мөнхбаатар | Улсын Их Хурлын гишүүн |
| Г.Мөнхцэцэг | Улсын Их Хурлын гишүүн |
| Н.Наранбаатар | Улсын Их Хурлын гишүүн |
| Т.Энхтүвшин | Улсын Их Хурлын гишүүн |

**Цөөнхийг төлөөлөн:**

| | |
|---|---|
| Ш.Адьшаа | Улсын Их Хурлын гишүүн |
| Б.Бейсен | Улсын Их Хурлын гишүүн |
| С.Ганбаатар | Улсын Их Хурлын гишүүн |
| Н.Ганибал | Улсын Их Хурлын гишүүн |
| Т.Доржханд | Улсын Их Хурлын гишүүн |

6.Улсын Их Хурлаас хугацааг сунгахаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь энэ тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор тусгай шалгалт явуулж, тайланг санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ

᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠐ - ᠨ ᠡᠳᠦᠷ    ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠓᠑    ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠵᠠᠷᠢᠮ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠣᠷᠢᠨ ᠲᠠᠪᠤᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠬᠡᠰᠡᠭ, ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠓᠐ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠓᠐.᠑ ... ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠴᠢᠭᠤᠯᠭᠠᠨ ᠤ ᠬᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨ ᠤ ᠳᠡᠭ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ... ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ... ᠢ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠠᠴᠠ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠬᠤ ᠨᠢ:

᠑. ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ...

᠒. ...

᠓. ...

[illegible]

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр — Дугаар 1 — Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах тухай**

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоол, “Журмын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 118 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД — С.АМАРСАЙХАН**

Засгийн газрын 2022 оны 1 дүгээр
тогтоолын хавсралт

# КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИНД ҮНДЭСЛЭН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

## Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журам нь коронавируст халдвар /КОВИД-19/ (цаашид “халдвар” гэх)-ын тархалтын түвшин, дархлаажуулалтын хамралт, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн уг халдварын үеийн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулахдаа хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах зарчим баримтална.

1.3.Энэ журамд заасан хуулийн этгээд гэдэгт Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг ойлгоно.

## Хоёр.Халдварын тархалтын түвшин

2.1.Халдварын тархалтын үе шат нь дараах түвшинтэй байна:

2.1.1.ногоон түвшин;

2.1.2.шар түвшин;

2.1.3.улбар шар түвшин;

2.1.4.улаан түвшин.

2.2.Халдварын тархалтын түвшинг тодорхойлох түр зааврыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## Гурав.Зохион байгуулалтын арга хэмжээ

3.1.Халдварын тархалтын түвшинг тогтоосон үнэлгээний тайланг Халдварт өвчин судлалын үндэсний төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар 7 хоног бүр тогтоож, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны онцгой комисст тус тус хүргүүлнэ.

3.2.Эрүүл мэндийн байгууллагын санал, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, орон нутгийн онцлог, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нөөц, хүчин чадлаас хамаарч коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинд хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны горимд нийцүүлэн тухайн шатны онцгой комисс хариу арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3.Стратегийн ач холбогдол бүхий салбар, бүс нутагт хүн, хуулийн этгээдийн хэрэгжүүлэх арга хэмжээг шаардлагатай тохиолдолд Улсын онцгой комисс тогтооно.

3.4.Халдварын тархалтын түвшинг харгалзан бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх эсэх асуудлыг аймаг, нийслэлийн онцгой комисс боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөнөөр шийдвэрлэнэ.

**Дөрөв.Халдварын тархалтын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл**

4.1.Халдварын тархалтын түвшинтэй уялдуулан бүх шатны онцгой комисс дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1.1.“Ногоон түвшин”-д хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлахгүй, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана;

4.1.2.“Шар түвшин”-д бүх төрлийн үйл ажиллагааг хязгаарлахгүйгээр Улсын онцгой комиссоос баталсан журмын дагуу байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл, шаардлагыг мөрдөж ажиллана;

4.1.3.“Улбар шар түвшин”-д хариуцлагын гэрээ байгуулж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг тодорхой хүрээнд хязгаарлана;

4.1.4.“Улаан түвшин”-д нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг тогтоож, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулна.

4.2.Халдварын тархалтын түвшин бүрд хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг энэ журмын хавсралтад заасан горимоор зохицуулна.

4.3.Хүн, хуулийн этгээд нь энэ журмын хавсралтад заасан горимын дагуу үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллана.

**Тав.Хариуцлага**

5.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинд хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журмын хавсралт

## ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

### НЭГ. ХУВЬ ХҮН, ГЭР БҮЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

| Түвшин | I | II | III | IV |
|---|---|---|---|---|
| | Ногоон түвшин (Тархалт бага тогтвортой) | Шар түвшин (Зөөвөрлөгдсөн/алаг цоог тархалттай) | Улбар шар түвшин (Халдвар голомтот тархалттай) | Улаан түвшин (Халдвар хүн амын дунд тархсан) |
| | | Хязгаарлах үйл ажиллагаа | | Хязгаарлахгүй үйл ажиллагаа |
| Хувь хүн, гэр бүл | Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах | 1. Халдварын тархалт өндөртэй бус нутаг руу зорчихгүй байх;<br>2. Ойрын хавьтал болсон, эсвэл халдвар батлагдсан хүнтэй уулзахгүй байх;<br>3. Өндөр настан, бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, архаг хууч өвчтэй хүн олон нийтийн газраар аль болох явахгүй байх. | 1. Зочин урихгүй, айлд зочлохгүй байх;<br>2. Олон хүн цугларсан газарт аль болох очихгүй байх;<br>3. Хавьтал болсон үед нийгмийн харилцаанд орохгүй байх;<br>4. 12-оос доош насны хүүхдийг 18 цагаас хойш зохион байгуулах олон нийтийн арга хэмжээнд оролцуулахгүй байх;<br>5. Зөвхөн гэр бүл, хамаатан, садны хүмүүсийн оршуулгын үйл ажиллагаанд оролцох. | 1. Эмнэлгийн зайлшгүй тусламж, эмийн сангаар үйлчлүүлэх;<br>2. Өмгөөлөл, нотариатаар үйлчлүүлэх;<br>3. Оршин суугаа хорооны хүнсний дэлгүүр, борлуулалтын цэг, худгаас хүнс, ахуйн хэрэглээний бараа, түлш, зөөврийн ус авах;<br>4. Газар тариалан эрхлэх;<br>5. Оршуулгын үйл ажиллагаанд оролцох. |

| Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага | | | | |
|---|---|---|---|---|
| Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах | 1. Шаардлагатай үед амны хаалт зүүх;<br>2. Хүн хооронд 1,5-2 метрээс доошгүй зай барих. | 1. Олон нийтийн газар, дотоод орчинд амны хаалт зүүх;<br>2. Хүн хооронд 1,5-2 метрээс доошгүй зай барих;<br>3. Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг сахих;<br>4. Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд утсаар зөвлөгөө авах, өөрийгөө тусгаарлах, дэглэм сахих. | 1. Олон нийтийн газар, дотоод орчинд амны хаалт зүүх;<br>2. Хүн хооронд 1,5-2 метрээс доошгүй зай барих;<br>3. Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг сахих;<br>4. “Гэр-ажил-гэр” “Гэр-сургууль-гэр” зарчим баримтлах;<br>5. Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд утсаар зөвлөгөө авах, өөрийгөө тусгаарлах, дэглэм сахих. | 1. Гэрээс гарахгүй байх зарчмыг баримтлах;<br>2. Гадаад, дотоод орчинд амны хаалт зүүх;<br>3. Нэн шаардлагатай хүнс, эм, түлш, ус худалдан авахаар айл, өрхөөс 1 хүн гарах;<br>4. Айлд зочлохгүй, зочин урихгүй байх;<br>5. Хүн хооронд 2 метрээс доошгүй зай барих;<br>6. Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлах;<br>7. Төрөөс зохион байгуулж байгаа халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;<br>8. Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 100, 119 дүгээр утсаар зөвлөгөө авах. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Дархлаа-жуулалт | 1. Дархлаажуулалтын тухай хуулийн 6.2.1-д "Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шаардлагын дагуу сэргийлэх тарилга хийлгэх үүрэг хүлээнэ." гэж заасныг хэрэгжүүлэх;<br>2. Дархлаажуулалтад товлолт хугацаанд хамрагдах;<br>3. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг дархлаажуулалтад хамрагдсаныг нотлох баримт, магадлагааг цахим болон цаасан хэлбэрээр авч явах. | | | |
| Зорчих хөдөлгөөн | Халдвараас сэргийлэх дэглэм сахих. | 1. Аль болох хувийн унаагаар зорчих;<br>2. Хүн хоорондын зай барих;<br>3. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо халдвараас сэргийлэх дэглэм баримтлах. | 1. Хүн хоорондын зай барих;<br>2. Нэг суудал алгасаж суух;<br>3. Халдвараас сэргийлэх дэглэм сахих;<br>4. Эрсдэлт бүлгийн хүн ам (өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт) нийтийн тээврийн үйлчилгээний оргил цагаар аль болох зорчихгүй байх. | 1. Зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд зорчихгүй байх;<br>2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн "А13", "Б13" маягттай зорчих;<br>3. Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай нэвтрэх;<br>4. Цахилгаан шат аль болох ашиглахгүй байх;<br>5. Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай зорчих. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтрэх | 1. Халдвараас сэргийлэх дэглэм сахих;<br>2. Шаардлагатай тохиолдолд асуумж өгч нэвтрэх. | Халдвараас сэргийлэх дэглэм сахих. | 1. Халдвараас сэргийлэх дэглэм сахих;<br>2. Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай нэвтрэх. | 1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн “А13”, “Б13” маягттай нэвтрэх;<br>2. Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай нэвтрэх;<br>3. Товчооны гадна ажиллаж, амьдардаг хүн байнга оршин суугаа газрын баг, хорооны тодорхойлолттой нэвтрэх;<br>4. Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай нэвтрэх. |

## ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

| Түвшин | I | II | III | IV |
|---|---|---|---|---|
| | **Ногоон түвшин (Тархалт бага тогтвортой)** | **Шар түвшин (Зөөвөрлөгдсөн/алаг цоог тархалттай)** | **Улбар шар түвшин (Халдвар голомтот тархалттай)** | **Улаан түвшин (Халдвар хүн амын дунд тархсан)** |
| | | | **Хүчин чадлын 50 хувийг хязгаарлах** | **Хязгаарлахгүй үйл ажиллагаа** |
| Хуулийн этгээд | Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах | 1. Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах;<br>2. Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахдаа дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдсан, эсхүл түргэвчилсэн шинжилгээнд хамрагдаж сөрөг хариу гарсан ажилтан, уран бүтээлч, үйлчлүүлэгч нарыг оролцуулах. | 1. Бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээ, хурал, цуглаан, цайллага, хүлээн авалт, хурим, найр;<br>2. Биеийн тамир, спортын үйл ажиллагаа;<br>3. Соёл, урлагийн арга хэмжээ;<br>4. Аялал зугаалга (гэр бүлээс бусад);<br>5. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар (Ресторан, кафе, сүлжээ хоолны газар, түргэн хоолны газар, кофе шоп, цайны газар, буфет, явуулын үйлчилгээтэй хоолны газар); | 1. Хууль тогтоох, төрийн захиргааны байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Авлигатай тэмцэх газар;<br>2. Эрүүл мэндийн байгууллага;<br>3. Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд (Байгаль орчныг хамгаалах, гааль, дипломат алба, онцгой байдал, мэргэжлийн хяналт, зэвсэгт хүчин бусад цэрэг, татвар, тусгай алба, гадаадын иргэн, харьяат, улсын бүртгэл, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ИНЕГ, түүний харьяа алба, салбар нэгж);<br>4. Шүүх, прокурор, өмгөөлөл, нотариат;<br>5. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллага;<br>6. Нисэх онгоцны буудал, агаарын тээвэрлэгчид; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 6. Бүх төрлийн баар;<br>7. Хүнснээс бусад барааны зах, худалдааны төв;<br>8. Дотоод орчинд өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа;<br>9. Цахим болон бүх төрлийн тоглоомын газар;<br>10. Сургалтын төв;<br>11. Үзвэр үйлчилгээ;<br>12. Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв;<br>13. Саун, бассейн, нийтийн халуун ус, алжаал тайлах төв;<br>14. Амралт, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал;<br>15. Шашны зан үйл, сүм, хийд, мөргөлийн газрууд. | 7. Эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, хот, нийтийн аж ахуй;<br>8. Шуудан, харилцаа холбоо;<br>9. Шатахуун, түлшний үйлдвэрлэл, хангамж, нийлүүлэлт, түгээлт, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын түлшний тээвэрлэлт, худалдаа;<br>10. Геологи, хайгуул, уул уурхай, газрын тосны олборлолт;<br>11. Хоол үйлдвэрлэл, түгээлт (зөвшөөрөл бүхий);<br>12. Зайны сургалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ, асрамж, халамж, түр хамгаалах байр;<br>13. Монголын улаан загалмай нийгэмлэг;<br>14. Газар тариалан, мал, амьтны өвс, тэжээлийн түгээлт, тээвэрлэлт;<br>15. Хүний болон малын эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага;<br>16. Хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт, сав баглаа боодол; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 17.Банк, автомат тооцооны машин;<br>18.Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа (эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр);<br>19.Хэвлэл мэдээлэл (зөвшөөрөл бүхий);<br>20.Дугуй засварын газар;<br>21.Оршуулгын үйл ажиллагаа. |
| **Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага** | | | | |
| Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах | 1. Шаардлагатай үед амны хаалт зүүх;<br>2. Хүн хоорондын зай барих. | 1. УОК-оос баталсан журмын дагуу байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг мөрдөж ажиллах;<br>2. Байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх; | 1. Хариуцлагын гэрээ байгуулах (Төрийн байгууллагад хамаарахгүй);<br>2. Байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;<br>3. Албан бичиг, баримтыг цахимаар хүлээн авах, солилцох; | 1. Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах);<br>2. Ажиллаж байгаа албан хаагчдын хоол үйлдвэрлэл, түгээлт (аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар тогтоосон горимоор);<br>3. Шаардлагатай яам, агентлаг, байгууллага 24 цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэх, шуурхай штабын бүрэлдэхүүнийг томилж, Улсын онцгой комиссын Шуурхай штабтай мэдээ, мэдээлэл шуурхай солилцож, ажиллах; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3. Улиралд нэг удаа урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлгэх;<br>4. Халдвар авсан хүнийг ажлын байранд ажиллуулахгүй байх;<br>5. Ажилтан, албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах талаар уриалах. | 4. Улиралд нэг удаа урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлгэх;<br>5. Ажлын байранд зайлшгүй ирэх шаардлагагүй ажил үүргийг цахимаар гүйцэтгэх;<br>6. Ойрын хавьтал, халдвар авсан хүнийг ажлын байранд ажиллуулахгүй байх;<br>7. Ажилтан, албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах талаар уриалах;<br>8. Хурал, цуглааныг цахимаар хийх;<br>9. Цагийн хязгаарлалт тогтоож болно. | 4. Амны хаалт тогтмол зүүх;<br>5. Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах;<br>6. Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах;<br>7. Албан бичиг, баримтыг цахимаар хүлээн авах, солилцох;<br>8. Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах;<br>9. Нэг өрөөнд 3-аас дээш ажилтан, албан хаагч хамт ажиллахгүй, хооллохгүй байх;<br>10. Ажлын байранд өдөрт 2 удаа чийгтэй цэвэрлэгээ хийх;<br>11. Өрөө, тасалгаанд агаар сэлгэлт хийх;<br>12. Стратегийн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа, боодлын үйлдвэрийн хангамж, нийлүүлэлт болон хүнсний салбарын ажилчдын ажлын хуваарь, зорчих хөдөлгөөнийг зохицуулах;<br>13. Тусгайлсан сав баглаа, боодолтой хүнсний бүтээгдэхүүнийг цахим захиалгын дагуу гараас үүдэнд хүргэх, авах. |
| Дархлаа-жуулалт | Дархлаажуулалтын тухай хуулийн 7.2-т “Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ажилтнуудыг сэргийлэх тарилгад бүрэн хамруулах үүрэг хүлээнэ.” гэж заасныг хэрэгжүүлэх | | | УОК-оос гаргасан шийдвэрийг дагаж мөрдөх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй байгууллага | Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах. | 1. УОК-оос баталсан журмын дагуу байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг мөрдөж ажиллах;<br>2. Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах. | 1. Нэг суудал алгасаж суулгах тэмдэглэгээ тавих, мөрдөх;<br>2. Нийтийн тээврийн хэрэгслийг өдөрт нэг удаа цэвэрлэх, агаар сэлгэлт хийх;<br>3. Хүн хоорондын зай бариулах;<br>4. Халдвараас сэргийлэх дэглэм сахиулах;<br>5. Халдвараас урьдчилан сэргийлэх сурталчилгааг тогтмол хийх. | 1. Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар тусгайлан заасан чиглэл, маршрут, цагийн хуваарьт шилжүүлэх;<br>2. Суудал алгасаж 1 зорчигч суулгах;<br>3. Хүн хоорондын зай барих;<br>4. Халдвараас сэргийлэх дэглэм сахиулах;<br>5. Халдвараас урьдчилан сэргийлэх сурталчилгааг тогтмол хийх;<br>6. Хяналтын байцаагч ажиллуулах. |
| Зорчих хөдөлгөөн | Халдвараас сэргийлэх дэглэм сахих | 1. Аль болох хувийн унаагаар зорчих;<br>2. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо халдвараас сэргийлэх дэглэм баримтлах. | 1. Аль болох хувийн унаагаар зорчих;<br>2. Хүн хоорондын зай барих;<br>3. Нэг суудал алгасаж суух;<br>4. Халдвараас сэргийлэх дэглэм сахих;<br>5. Эрсдэлт бүлгийн хүн ам (өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт) нийтийн тээврийн үйлчилгээний оргил цагаар аль болох зорчихгүй байх. | 1. Зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд зорчихгүй байх;<br>2. Хязгаарлалтад хамаарахгүй байгууллагын ажилтан, албан хаагчид байгууллагын тодорхойлолт, ажлын үнэмлэхтэй (аймгийн нутаг дэвсгэрт);<br>3. Нэг суудал алгасаж суух;<br>4. Халдвараас сэргийлэх дэглэм сахих;<br>5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн “А13”, “Б13” маягттай зорчих;<br>6. Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай зорчих. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо | Халдвараас сэргийлэх дэглэм сахих. | 1. Шаардлагатай тохиолдолд асуумж авч нэвтрүүлэх;<br>2. Халдвараас сэргийлэх дэглэм сахих. | 1. Орох гарах тээврийн хэрэгслийг хязгаарлах;<br>2. Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх. | 1. Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх;<br>2. Албан томилолт, зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгслийг улс, аймаг, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр нэвтрүүлэх. |

Жич:
-Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл, шаардлагыг Улсын онцгой комисстой зөвшилцсөнөөр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.
-Хилийн нэвтрэх цэгт баримтлах үйл ажиллагааны горимыг Улсын онцгой комисс тогтооно.
-Дээрх хүснэгтэд дурдагдаагүй салбарын үйл ажиллагаа халдвараас сэргийлэх дэглэм баримтлан бүх түвшинд явагдана.

**Хаяг:**
“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 3.5
**Индекс: 200003**